

**1. “АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН БАРИЛГА, ЗАСВАРЫН АЖЛЫН ТӨСӨВ
БОДОХОД ХЭРЭГЛЭХ АЖИЛЧДЫН ЦАГИЙН ТАРИФТ ЦАЛИНГИЙН ЖИШИГ”
ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛАХ АЖИЛ**

“Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодоход хэрэглэх ажилчдын цагийн тарифт цалингийн жишиг” шинэчлэн боловсруулах ажлыг “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын захирал Х.Пүрэвжаргалын баталсан 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн №11 тоот ажлын даалгавар, Захиалагч “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-аар болон зөвлөх “Монголын авто замчдын холбоо” ТББ-ын хооронд байгуулсан 2023 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн № 2023/03-05 тоот гэрээний дагуу хийж гүйцэтгэсэн.

“Авто зам, замын байгууламжийн төсөв бодоход хэрэглэх ажилчдын цагийн тарифт цалингийн жишиг”, “Авто зам, замын байгууламжийн машин механизм, тоног төхөөрөмжийн нэг машин цагийн жишиг үнэ”-ийг шинэчлэн боловсруулах ажлын эцсийн шатны тайланд редакци, шүүмж хийсэн ажлын хэсгийн 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн тайлангийн 6-д заасан “Ажлын хэсгийн нэгдсэн дүгнэлт, санал зөвлөмж”-ийн дагуу дутуу ажлуудыг бүрэн дуусгаж, ЗТХЯ, “ЗТХТ” ТӨҮГ, МАЗХ-ны төлөөлөл болон редакци, ажлын хэсгийн хамтарсан хурал, уулзалтыг удаа дараа зохион байгуулж, тарифт цалингийн өөрчлөлтийг инфляци, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулан тооцсон 1 дүгээр зэргийн хөлс авагчийн цалинг 85%-иар нэмэгдүүлэх саналыг Авто замын салбарын “Шинжлэх ухаан, техникийн зөвлөл”, Зам, тээврийн хөгжлийн яамны “Шинжлэх ухаан, технологийн зөвлөл”-ийн хурлаар хэлэлцүүлж 100%-ийн саналаар дэмжигдсэн.

Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодоход хэрэглэх ажилчдын тарифт цалингийн жишиг (ЗТХ-ийн сайдын 2019 оны 275 дугаар тушаалаар батлагдсан)

Үзүүлэлт		Мэргэжлийн зэрэг					
Тарифын итгэлцүүр		I	II	III	IV	V	VI
		1	1.11	1.25	1.44	1.66	1.92
Хөдөлмөрийн хэвийн нөхцөлд ажилладаг	Цагаар хөлс авагчид	3764	4177	4705	5421	6248	7225
	Хийснээр хөлс авагчид	4165	4623	5207	5998	6915	7997

Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодоход хэрэглэх ажилчдын тарифт цалингийн жишиг (төсөл 2024 он)

Үндэслэл	Үзүүлэлт		Мэргэжлийн зэрэг						
	Тарифын итгэлцүүр		I	II	III	IV	V	VI	
Инфляци, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулан тооцсон			1	1.22	1.44	1.62	1.78	1.92	
		Хөдөлмөрийн хэвийн нөхцөлд ажилладаг	Цагаар хөлс авагчид	6963	8495	10027	11280	12394	13367
			Хийснээр хөлс авагчид	7705	9400	11095	12482	13715	14794